



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/9/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2021 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn Аудитор: Ж.Баяртуул Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.03.24 № 354  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨЛӨНБУЙР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
У.ГАНХУЯГ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Хөлөнбуйр сумын нэгтгэсэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын нэгтгэсэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хөлөнбуйр сумын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 87,5 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.




**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>761,551,668.54</b>	<b>761,014,227.62</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	142,848,717.17	169,755,465.24
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	142,848,717.17	169,755,465.24
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	142,848,717.17	169,755,465.24
31211	Төрийн сангийн харилцах	139,656,952.35	162,987,072.84
31213	Арилжааны банк дахь харилцах	3,191,764.82	6,768,392.40
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	277,019,920.64	245,547,321.30
33400	Зээлийн хүүгийн авлага	5,311,209.78	5,108,465.78
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	271,539,907.22	240,438,855.52
3351	Байгууллагаас авах авлага	30,382,192.00	13,915,580.30
3352	Хувь хүмүүсээс авах авлага	241,157,715.22	226,523,275.22
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	341,683,030.73	345,711,441.08
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,361,403.72	12,041,424.90
35130	Эм боох материал	1,361,403.72	12,041,424.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	163,053,533.01	159,412,922.18
35410	Бичиг хэргийн материал	7,520,750.70	10,622,382.64
35420	Аж ахуйн материал	106,963,179.76	85,713,777.86
35440	Түлц, шатах тослох материал	8,236,680.00	2,012,187.63
35460	Хүнсний материал	345,871.55	4,702,124.05
35470	Бусад хангамжийн материал	39,987,051.00	56,362,450.00
35600	Мал амьтад	177,268,094.00	174,257,094.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,674,383,168.40</b>	<b>6,898,818,366.58</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,674,383,168.40	6,898,818,366.58
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,552,815,188.18	6,778,196,076.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,400,685,530.37	3,642,793,529.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	(219,227,929.28)	(332,508,206.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	233,962,760.00	271,862,760.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(104,585,193.38)	(131,696,527.96)
39205	Машин тоног төхөөрөмж	410,892,196.93	499,691,657.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(248,289,087.58)	(293,417,356.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	167,521,574.33	179,616,247.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(121,915,968.07)	(131,388,483.18)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,581,000,000.00	2,581,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(129,049,999.92)	(193,574,999.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,353,707,243.63	1,523,163,440.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	(782,898,934.85)	(851,522,480.87)
39217	Ном	11,012,996.00	14,176,496.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	121,567,980.22	120,622,289.94
39301	Програм хангамж	5,640,250.00	5,640,250.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,982,269.78)	(3,927,960.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	118,910,000.00	118,910,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,435,934,836.94</b>	<b>7,659,832,594.20</b>

4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>31,931,690.00</b>	<b>15,714,726.14</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	31,931,690.00	15,714,726.14
413	<b>Өглөг</b>	31,931,690.00	15,714,726.14
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	56,035.00	821,752.14
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	10,000.00
4136	<b>Бусад өглөг</b>	31,875,655.00	14,882,974.00
41361	Байгууллагад төлөх өглөг	31,796,155.00	13,685,525.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,197,449.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,404,003,146.94</b>	<b>7,644,117,868.06</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,404,003,146.94	7,644,117,868.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,501,544,898.27	1,501,544,898.27
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,862,921,983.60	5,103,036,704.72
51210	Өмнөх үеийн үр дүн	4,699,162,838.32	4,862,921,983.60
51220	Тайлант үеийн үр дүн	163,759,145.28	240,114,721.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,039,536,265.07	1,039,536,265.07
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,435,934,836.94</b>	<b>7,659,832,594.20</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,879,726,651.30</b>	<b>2,712,575,838.74</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>38,521,104.18</b>	<b>57,261,642.19</b>
110	<b>Орлогын албан татвар</b>	30,227,149.18	36,152,770.19
1100	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	30,227,149.18	36,152,770.19
110002	Үйл ажиллагааны орлого	15,196,225.63	2,463,820.00
110003	Хөрөнгийн орлого		12,363,131.19
110008	Шууд бус орлого	15,030,923.55	21,325,819.00
113	<b>Хөрөнгийн албан татвар</b>	2,200,000.00	4,570,000.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	30,000.00	2,260,000.00
113002	Бууны албан татвар	2,170,000.00	2,310,000.00
118	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	6,093,955.00	16,538,872.00
1180	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	6,093,955.00	4,855,852.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,917,730.00	2,855,852.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,176,225.00	2,000,000.00
1181	<b>Газрын төлбөр</b>	-	10,303,936.00
118101	Газрын төлбөр		10,104,832.00
118102	Дуудлага худалдаа		199,104.00
1182	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	-	1,379,084.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		1,379,084.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>677,103,429.81</b>	<b>731,182,980.05</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	677,103,429.81	731,182,980.05
120002	Хүүгийн орлого	10,458,955.16	152,674.00
120003	Торгуулийн орлого	23,781,000.00	52,650,658.00

Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,440,653.52	625,578,361.07
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,339,000.00	600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	566,515,037.52	624,978,361.07
120009	Бусад орлого	8,709,534.00	2,717,042.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	33,713,287.13	50,084,244.98
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,164,102,117.31</b>	<b>1,924,131,216.50</b>
<b>1310</b>	<b>Удсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>892,555,800.00</b>	<b>1,080,944,042.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	892,555,800.00	1,080,944,042.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>185,772,735.47</b>	<b>256,054,694.50</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	35,700.00	1,105,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ,Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	2,173,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,553,115.00	224,617,324.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,183,920.47	28,159,370.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,073,595,481.84</b>	<b>568,484,400.00</b>
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	454,214,200.00	509,852,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	69,418,100.00	58,632,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,178,100.00</b>	<b>18,648,080.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,178,100.00	18,648,080.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,512,600,526.55</b>	<b>2,349,733,741.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,512,600,526.55</b>	<b>2,349,733,741.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,934,632,833.54</b>	<b>2,308,821,045.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>924,821,222.02</b>	<b>1,169,355,538.80</b>
210101	Үндсэн цалин	890,957,866.72	1,135,030,915.80
210102	Нэмэгдэл	7,367,975.00	9,360,982.00
210104	Урамшуулал	26,495,380.30	24,963,641.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>117,924,391.52</b>	<b>147,245,390.55</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,931,712.53	101,072,672.40
210202	Тэтгэмжийн даатгал	9,451,200.03	11,875,460.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,448,320.01	9,312,208.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,826,650.81	2,269,841.87
210205	Эрүүл мэндийн даатгал	18,266,508.14	22,715,207.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>101,840,216.00</b>	<b>113,050,290.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,712,076.00	19,845,433.23
210302	Тулш, халаалт	77,058,251.00	91,545,157.00
210303	Цэвэр, бохир ус	3,069,889.00	1,659,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>62,205,303.00</b>	<b>95,158,803.52</b>
210401	Бичиг хэрэг	16,604,811.00	8,984,408.00
210402	Тээвэр, шатахуун	25,889,964.00	27,608,370.52
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	11,064,600.00	11,590,020.00
210404	Ном, хэвлэл	1,030,140.00	996,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,381,688.00	3,519,365.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,234,100.00	10,190,666.00
210408	Бараа материал акталсны зардал		32,269,374.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>93,138,557.14</b>	<b>78,082,030.40</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,280,844.14	33,350,537.40
210502	Хоол, хүнс	62,211,713.00	40,790,493.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,646,000.00	3,941,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,680,026.47</b>	<b>15,593,150.50</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	652,500.00	1,263,480.50
210604	Урсгал засвар	23,027,526.47	14,329,670.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,691,200.00</b>	<b>9,045,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,691,200.00	9,045,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,152,558.94</b>	<b>71,099,330.63</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,822,333.94	21,289,139.23
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,600,000.00	1,682,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	867,060.00	752,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,500.00	361,376.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	298,776.00	156,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	210,300.00
210807	Газрын төлбөр	521,968.00	219,078.00
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	30,688,255.00	46,428,137.40
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>537,179,358.45</b>	<b>610,191,510.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,246,564.47	266,463,841.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,346,900.00	3,169,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	324,585,893.98	340,558,168.96

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	577,967,693.01	40,912,696.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,942,710.00	10,951,970.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,856,910.00	10,651,970.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,085,800.00	300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,061,801.17	29,960,726.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,061,801.17	29,960,726.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>367,126,124.75</b>	<b>362,842,096.79</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	203,366,979.47	122,727,375.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		200,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	203,366,979.47	122,527,375.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(203,366,979.47)	(122,727,375.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>163,759,145.28</b>	<b>240,114,721.79</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<b>2,387,421,277.65</b>	<b>2,193,827,465.67</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	<b>38,521,104.18</b>	<b>57,261,642.19</b>
110	Орлогын албан татвар	30,227,149.18	36,152,770.19
1100	Хувь хүний орлогын албан татвар	30,227,149.18	36,152,770.19
110002	Үйл ажиллагааны орлого	15,196,225.63	2,463,820.00
110003	Хөрөнгийн орлого		12,363,131.19
110008	Шууд бус орлого	15,030,923.55	21,325,819.00
113	Хөрөнгийн албан татвар	2,200,000.00	4,570,000.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	30,000.00	2,260,000.00
113002	Бууны албан татвар	2,170,000.00	2,310,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	6,093,955.00	16,538,872.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,093,955.00	4,855,852.00
118001	Улсын тэмдэгийн хураамж	3,917,730.00	2,855,852.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,176,225.00	2,000,000.00
1181	Газрын төлбөр	-	10,303,936.00
118101	Газрын төлбөр		10,104,832.00
118102	Дуудлага худалдаа		199,104.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	1,379,084.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		1,379,084.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>154,441,756.16</b>	<b>170,909,294.98</b>
120	Нийтлэг татварын бус орлого	154,441,756.16	170,909,294.98
120002	Хүүгийн орлого	10,458,955.16	355,418.00
120003	Торгуулийн орлого	23,781,000.00	52,650,658.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	72,157,980.00	65,101,932.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,818,980.00	53,426,040.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,339,000.00	11,675,892.00
120009	Бусад орлого	8,709,534.00	2,717,042.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	39,334,287.00	50,084,244.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>2,194,458,417.31</b>	<b>1,965,656,528.50</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	892,555,800.00	1,080,944,042.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	892,555,800.00	1,080,944,042.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	185,772,735.47	285,334,356.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	35,700.00	1,105,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	2,173,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,553,115.00	253,896,986.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,183,920.47	28,159,370.00



**Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,103,951,781.84</b>	<b>580,730,050.00</b>
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	39,105,281.84	12,245,650.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	454,214,200.00	509,852,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	69,418,100.00	58,632,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,178,100.00</b>	<b>18,648,080.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,178,100.00	18,648,080.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,069,262,540.54</b>	<b>1,967,895,866.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,069,262,540.54</b>	<b>1,967,895,866.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,460,494,826.53</b>	<b>1,915,978,515.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>945,793,436.71</b>	<b>1,196,114,700.75</b>
210101	Үндсэн цалин	789,212,962.76	807,747,037.08
210102	Нэмэгдэл	60,613,094.75	277,078,082.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,927,000.00
210104	Урамшуулал	78,046,480.20	82,682,684.85
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	15,604,677.00	24,679,896.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>118,825,239.54</b>	<b>149,454,685.23</b>
210201	Тэтгэврийн даатгал	78,643,699.39	98,637,936.50
210202	Тэтгэмжийн даатгал	9,237,308.82	11,607,941.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,349,613.47	9,261,951.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,828,496.49	2,314,014.38
210205	Эрүүл мэндийн даатгал	18,326,757.17	23,139,968.02
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	3,439,364.20	4,492,873.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>100,601,852.87</b>	<b>114,617,461.09</b>
210301	Гэрэл, цахилгаан	26,893,405.00	23,875,950.84
210302	Түлш, халаалт	70,173,559.00	87,976,130.25
210303	Цэвэр, бохир ус	3,069,889.00	1,869,700.00
210304	Байрны түрээс	464,999.87	895,680.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>59,331,254.00</b>	<b>64,140,069.00</b>
210401	Бичиг хэрэг	12,150,470.00	8,821,810.00
210402	Тээвэр, шатахуун	25,251,294.00	24,512,104.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,064,600.00	12,391,020.00
210404	Ном, хэвлэл	1,138,040.00	1,115,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	4,598,515.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,726,850.00	12,701,620.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>83,731,622.00</b>	<b>77,994,307.85</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,147,089.50	27,361,149.85
210502	Хоол, хүнс	61,245,532.50	45,935,458.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,339,000.00	4,697,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>34,446,952.47</b>	<b>16,918,030.50</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,033,800.00	1,355,380.50
210604	Урсгал засвар	28,300,152.47	15,562,650.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,691,200.00</b>	<b>9,045,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,691,200.00	9,045,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,399,574.94</b>	<b>36,959,563.67</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,079,333.94	21,139,139.23
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,600,000.00	1,682,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	867,060.00	752,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	336,776.00	361,376.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	133,000.00	156,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	882,500.00	240,000.00
210807	Газрын төлбөр	222,634.00	219,078.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	13,278,271.00	12,408,670.44

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,673,694.00	250,734,697.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,483,594.00	247,988,697.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,190,100.00	2,746,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>608,767,714.01</b>	<b>51,917,351.51</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,386,431.00	9,710,975.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,300,631.00	9,410,975.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,085,800.00	300,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,418,101.17	42,206,376.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,418,101.17	42,206,376.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>318,158,737.11</b>	<b>225,931,599.07</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>296,360,715.47</b>	<b>149,024,851.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>296,360,715.47</b>	<b>149,024,851.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	296,360,715.47	149,024,851.00
223001	Бусад хөрөнгө	249,276,124.47	125,320,175.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,084,591.00	23,704,676.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>(296,360,715.47)</b>	<b>(149,024,851.00)</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	49,400,000.00	50,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	49,400,000.00	50,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>(49,400,000.00)</b>	<b>(50,000,000.00)</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(27,601,978.36)	26,906,748.07
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	170,450,695.53	142,848,717.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,848,717.17	169,755,465.24

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,501,544,898.27	1,039,536,265.07	4,699,162,838.32	7,240,244,001.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,501,544,898.27	1,039,536,265.07	4,699,162,838.32	7,240,244,001.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			163,759,145.28	163,759,145.28
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,501,544,898.27	1,039,536,265.07	4,862,921,983.60	7,404,003,146.94
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,501,544,898.27	1,039,536,265.07	4,862,921,983.60	7,404,003,146.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,501,544,898.27	1,039,536,265.07	4,862,921,983.60	7,404,003,146.94
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			240,114,721.12	240,114,721.12
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,501,544,898.27	1,039,536,265.07	5,103,036,704.72	7,644,117,868.06

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн н	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,827,807,200.00	1,774,761,697.19
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,676,185,700.00	1,629,797,822.19
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,664,380,800.00	1,620,386,847.19
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,181,064,200.00	1,163,937,304.75
210101	Үндсэн цалин	814,179,000.00	807,747,037.08
210102	Нэмэгдэл	287,365,900.00	277,078,082.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,927,000.00	3,927,000.00
210104	Урамшуулал	72,253,300.00	75,185,184.85
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ш</b>	149,988,400.00	144,961,811.88
210201	Тэтгэврийн даатгал	102,509,900.00	98,637,936.50
210202	Тэтгэмжийн даатгал	11,037,900.00	11,607,941.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,054,700.00	9,261,951.32
210204	Ажилгүйдлийн даатгал	5,605,800.00	2,314,014.38
210205	Эрүүл мэндийн даатгал	23,780,100.00	23,139,968.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	110,465,400.00	109,691,263.48
210301	Гэрэл, цахилгаан	19,960,700.00	19,845,433.23
210302	Түлш, халаалт	88,635,000.00	87,976,130.25
210303	Цэвэр, бохир ус	1,869,700.00	1,869,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,348,700.00	60,994,219.00
210401	Бичиг хэрэг	8,755,300.00	8,689,310.00
210402	Тээвэр, шатахуун	23,643,000.00	23,279,354.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,480,900.00	12,391,020.00
210404	Ном, хэвлэл	950,000.00	950,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн ус	4,600,000.00	4,598,515.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,919,500.00	11,086,020.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	80,467,300.00	68,298,155.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,021,000.00	19,020,747.85
210502	Хоол, хүнс	56,673,600.00	44,579,708.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,772,700.00	4,697,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,023,600.00	6,478,780.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,900,000.00	2,900,000.00
210604	Урсгал засвар	4,123,600.00	3,578,780.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,570,000.00	8,289,000.00
210702	Дотоод албан томилолт	8,570,000.00	8,289,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний т</b>	27,658,200.00	24,138,093.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил ү	24,217,200.00	20,839,139.23
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,682,500.00	1,682,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	640,000.00	640,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	454,000.00	361,376.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	156,000.00	156,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	222,700.00	219,078.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	36,795,000.00	33,598,219.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,049,000.00	30,852,219.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,746,000.00	2,746,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,804,900.00	9,410,975.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,804,900.00	9,410,975.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,804,900.00	9,410,975.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>101,621,500.00</b>	<b>94,963,875.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	101,621,500.00	94,963,875.00
223001	Бусад хөрөнгө	101,621,500.00	94,963,875.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН Ц</b>	50,000,000.00	50,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	50,000,000.00	50,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,827,807,200.00	1,752,932,074.19
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,068,328,000.00	1,050,983,315.49
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,068,328,000.00	1,050,983,315.49
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	614,284,400.00	618,198,746.70
132001	Орон нутгийн төсвөөс	555,652,100.00	559,566,446.70
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	58,632,300.00	58,632,300.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВ</b>	18,464,100.00	18,648,080.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,464,100.00	18,648,080.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГА</b>	126,730,700.00	65,101,932.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,000,000.00	53,426,040.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,600,000.00	11,675,892.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		50,897,026.31
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		29,422,821.31

## 2. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>66,884,412.00</b>	<b>285,334,356.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>66,884,412.00</b>	<b>270,637,180.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	66,884,412.00	258,091,530.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	7,497,500.00
210104	Урамшуулал	-	7,497,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,032,009.00	3,245,850.00
210401	Бичиг хэрэг	424,500.00	132,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,767,509.00	1,232,750.00
210404	Ном, хэвлэл	-	165,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840,000.00	1,715,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,080,000.00	11,596,152.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	336,000.00	10,240,402.00
210502	Хоол, хүнс	744,000.00	1,355,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	14,659,050.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,395,180.50
210602	Тавилга	-	280,000.00
210604	Урсгал засвар	-	11,983,870.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	756,000.00
210702	Дотоод албан томилолт	-	756,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	614,800.00	412,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,800.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	112,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	60,157,603.00	219,924,178.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,157,603.00	219,924,178.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	300,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>12,245,650.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,245,650.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>14,697,176.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	14,697,176.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	14,697,176.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	66,884,412.00	285,334,356.50
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	66,884,412.00	285,334,356.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,105,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,815,140.00	2,173,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,568,594.00	253,896,986.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,500,678.00	28,159,370.00

## 3. Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч У.Ганхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 24-ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хөлөнбуйр сум нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Иргэдийн хөгжлийг дэмжих жил

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2020 онд Хөлөнбуйр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хөлөнбуйр сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 2,632,250.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 52,645.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 2,472,461.1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 49,449.2 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

### **3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 223,897.8 мянган төгрөгөөр буюу 29.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	142,848.7	169,755.5	26,906.8
Авлага	277,019.9	245,547.3	-31,472.6
Урьдчилгаа			
Бараа материал	341,683.0	345,711.4	4,028.4
Үндсэн хөрөнгө	6,674,383.2	6,898,818.4	224,435.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,435,934.8</b>	<b>7,659,832.6</b>	<b>223,897.8</b>
Өр төлбөр	31,931.7	14,882.9	-17,048.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,404,003.1	7,644,949.7	240,946.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,435,934.8</b>	<b>7,659,832.6</b>	<b>223,897.8</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 169,755.5 мянган төгрөг болж 26,906.8 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн орлогын дансанд төсвийн төвлөрүүлэлт нэмэгдэж байршсанаас шалтгаалжээ

Авлага дансны үлдэгдэл 245,547.3 мянган төгрөг болж 31,472.6 мянган төгрөгөөр буурсан нь урьд оны авлага барагдуулсан, сум хөгжлийн сангийн авлагыг барагдуулсан зэргээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2020 онуудад үүссэн, он удаан жил жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр иргэдэд олгосон 205,555.1 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 345,711.4 мянган төгрөг болж 4,028.4 мянган төгрөгөөр буурсан нь цаг үеийн байдлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,898,818.4 мянган төгрөг болж 224,435.2 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 512,458.6 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 23,704.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 30,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,000.0 мянган төгрөг, акталсан 11,671.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,714.7 мянган төгрөг болж 17,048.8 мянган төгрөгөөр буурсан нь төлбөр тооцоо барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,644,117.8 мянган төгрөг болж 240,946.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үр дүнгийн нийт орлого өмнөх оноос 31,158.8 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 162,866.8 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь өмнөх оны үлдэгдлээс санхүүжилт төлөвлөж хөрөнгө оруулалт болон тоног төхөөрөмж, урсгал зардлуудыг буурснаас шалтгаалсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

## **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,832,013.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,832,013.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4,206.3 мянган төгрөгөөр бууруулж 1,827,807.2 мянган төгрөгөөр баталсан байна

## **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,827,807.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,068,328.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 38,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 555,652.1 мянган төгрөгийг орон нутгаас, 58,632.3 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгээр, 16,600.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор, 18,464.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалаас, 72,130.7 мянган төгрөгийг урьд оны харилцахын үлдэгдлээс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,050,983.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 65,101.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 559,566.4 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 58,632.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалаас 18,648.1 мянган төгрөг, нийт 112,629.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,774,761.6 мянган төгрөгийг зарцуулж 59,187.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,774,761.6 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь ажиллагсдын орон тоо дутуу, хөрөнгө оруулалтын ажил дутуу, цар тахал өвчин гарсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын болон орон нутгийн гүйцэтгэх засаглал удирдлагын хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа арга хэмжээ 11,238.2 мянган төгрөгөөр, баг хорооны үйл ажиллагааны арга хэмжээнээс 3,919.5 мянган төгрөг, нөөцийн хөрөнгийн арга хэмжээ 2,324.9 мянган төгрөг, ангилагдаагүй зардал 871.8 мянган төгрөг, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн нэг хүнд ноогдох норматив арга хэмжээ 58.3 мянган төгрөгөөр эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний 84.3 мянган төгрөг, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний арга хэмжээний 2,020.2 мянган төгрөг, соёл урлаг хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ 1,722.30 мянган төгрөг, Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээнээс 893.3 мянган төгрөг, тогтмол зардлын 545.4 мянган төгрөг, хүүхдийн хоолны арга хэмжээ 6,559.8 мянган төгрөг, ерөнхий боловсрол хөтөлбөрийн тогтмол зардлын 417.7 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөр арга хэмжээнээс 4,063.3 мянган төгрөг, дотуур байрны үйлчилгээ арга хэмжээ 5,534.1 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## **Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого**

Хөлөнбуйр сум нь 2020 онд 45,800.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 112,629.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 245,9 хувиар биелүүлсэн байна.

## **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,173.0 мянга, хандив тусламжийн 1,105.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 253,896.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28,159.4 мянга, нийт 285,334.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин урамшуулалд 7,497.5 мянган төгрөг, хангамж материалд 3,245.8 мянган төгрөг, норматив зардалд 11,596.2 мянган төгрөг, урсгал болон эд хогшил авах зардал 14,659.1 мянган төгрөг, албан томилолт 756.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 220,336.9 мянган төгрөг, тэтгэмж 300.0 мянган төгрөг, биет бус хөрөнгө худалдан авсан 14,697.2 мянган төгрөг нийт 273,088.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 12,245.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт нэмэлт дансанд төвлөрүүлжээ

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа, мөнгөн дүнгүй 4 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 30,300.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 2* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	30,300.0	3	30,300.0	0	0	100
Нийт дүн	3	30,300.0	3	30,300.0	0	0	100

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 61,258.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 60,258.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Соёлын төвийн үр дүнгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад үнэ төлбөргүй орсон орлогын 1,0 сая төгрөгийг буруу бүртгэсэн тул санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, он дамжсан авлага болон сум хөгжлийн сангийн авлага барагдуулалтын талаар 3 албан шаардлага, санхүүгийн тайлангийн устгах бичилтийг бүрэн хийх 1 зөвлөмж тус тус хүргүүлээ.

1. Тайлант онд сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг захирамжтай тулган шалгахад Засаг дарга нь тайлант онд захирамжаар 28,3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт 11,9 сая төгрөгийн 12 захирамж нь Төсвийн тухай хуулийн 27.1.1-т "төсвийн зарчмыг мөрдлөг болгох", 27.4.4-т "хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага", Сангийн Сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалын 1.2, 2.1 дэх заалтуудтай нийцэхгүй, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

2. Сум хөгжлийн сангийн зээлийн хугацаа хэтрэлттэй 21 зээлдэгчийн 46,8 сая төгрөгийн авлага байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих" журмын 1.6.2-т "Зээлийн хугацаа нь 36 хүртэл сар байна." гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

3. Хөлөнбуйр сумын Соёлын төвийн авлага, өглөгийн бүртгэлийг харилцагч бүрээр тулган шалгахад он дамжсан 1,5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд авлага барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн санхүүгийн тайлангийн устгах бичилттэй холбоотой 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Сумын нийт дотоод устгалын дүн нь 618,020,753.3 төгрөг бөгөөд дээрх устгалыг бүрэн хийсэн байна. Харин орлого, зардлын нийт 590,213,951.04 төгрөгийн гадаад устгалыг аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахаар төлөвлөсөн байна. Иймд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд тус устгалын бичилтийг анхаарч үзье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

*Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлттэй холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн орлого, зардлын гадаад устгалыг аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн тусгах.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх.



1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Хөлөнбуйр сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код:
2020			ДОА-2021/9/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Хөлөнбуйр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа журамд нийцээгүй 11.9 сая төгрөгийн захирамж гаргаж зарцуулсан байна.	11,970.4	Албан шаардлага	Засаг дарга	У.Ганхуяг
2	Сум хөгжлийн сангийн хөрөнгөнөөс 2014 онд 53 иргэнд сумын хашааг жигдрүүлэхээр олгогдсон 46,8 сая төгрөгийн зээл одоог хүртэл барагдуулаагүй байна.	46,793.9	Албан шаардлага	Засаг дарга	У.Ганхуяг
3	Хөлөнбуйр сумын Соёлын төвийн авлага, өглөгийн бүртгэлийг харилцагч бүрээр тулган шалгахад он дамжсан 1,5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд авлага барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1,493.7	Албан шаардлага	Засаг дарга	У.Ганхуяг
4	Тайлант онд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа, мөнгөн дүнгүй 4 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.	0	Албан шаардлага	Засаг дарга	У.Ганхуяг
5	Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь устгах бичилтийг бүрэн хийхэд анхаарч ажиллах.	0	Зөвлөмж	Засаг дарга	У.Ганхуяг
6	Соёлын төвийн үр дүнгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад үнэ төлбөргүй орсон орлогын 1,0 сая төгрөгийг буруу бүртгэсэн тул санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав.	1,000,0	Залруулга	Засаг дарга	У.Ганхуяг
<b>ДҮН</b>		<b>61,258.0</b>			

